



СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 06 сарын 08 өдөр

дугаар 9/21

Улаанбаатар хот

Үндэсний стандарт шинээр болон
шинэчлэн батлах, хүчингүй болгох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.3, 11 дүгээр зүйлийн 11.3.1, 11.3.3, 11.3.4, 25 дугаар зүйлийн 25.3.2, СХЗГ-ын даргын 2020 оны А/267 дугаар тушаалаар батлагдсан “Техникийн хорооны хурлын дэг”, Үл эвдэх сорилын стандартчиллын техникийн хороо (TX 45)-ны дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нэгдүгээр хавсралтад дурдсан 2 стандартыг улсын хэмжээнд хэрэглэхээр хүлээн зөвшөөрч үндэсний стандартаар шинээр баталсугай.
2. Хоёрдугаар хавсралтад дурдсан 2 стандартыг улсын хэмжээнд хэрэглэхээр хүлээн зөвшөөрч үндэсний стандартаар шинэчлэн баталсугай.
3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан гуравдугаар хавсралтад дурдсан 2 стандартыг хүчингүй болсонд тооцсугай.
4. Шинээр болон шинэчлэн баталсан стандартыг улсын мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн өдрөөс эхлэн мөрдсүгэй.
5. Шинээр болон шинэчлэн баталсан стандартыг сурталчилах ажлыг зохион байгуулахыг Монголын материал судлал гагнуурын нийгэмлэгт зөвлөмжилсүгэй.

ДЭД ДАРГА



ДДАРЬСҮХБААТАР

Бүртгэлийн дугаар	59
ХУУЛБАР ҮНЭН	
Мөр өдөр 1 Июнь Засгийн тааралтад	
ГАЗАР	
2021	06
И. Чижек	

098029369

БҮРТГЭВ.
2021.06.16

20.. оны ... сарын .. чиc 20.. оны ... сарын
хүртэл хүчинтэй

Стандартын мэдээлэлд, лавлагчны төв


Стандарт, хэмжил зүйн газрын даргын
2021 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ХТҮЗ154 9926039641 9096035

Шинээр баталсан стандартын жагсаалт

№	Стандартын нэр	Стандартын дугаар
1	Гагнуурчны мэргэжлийн шалгалт. Хайлуулж гагнах. 2-р хэсэг: Хөнгөн цагаан, түүний хайлш	MNS ISO 9606-2:2021
2	Гагнуур. Хөнгөн цагаан, түүний хайлшийн нуман гагнуурын холболт. Согогийн чанарын түвшин	MNS ISO 10042:2021




Стандарт, хэмжил зүйн газрын даргын
2021 оны ... дугаар сарын ...-ны ёдрийн
... дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Шинэчлэн баталсан стандартын жагсаалт

№	Стандартын нэр	Стандартын дугаар
1	Металлын гагнуурын холболтын эвдэх сорил. Хугалах сорил	MNS ISO 9017:2021
2	Гагнуурын холболтын үл эвдэх сорил. Хайлуулж гагнасан холболтын гадна үзлэгийн сорил	MNS ISO 17637:2021



Стандарт, хэмжил зүйн газрын даргын
2021 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар тушаалын гуравдугаар хавсралт

ХТУ3154 902063964 9026035

Хүчингүй болгосон үндэсний стандартын жагсаалт

№	Стандартын нэр	Стандартын тэмдэглэгээ	Стандартын тогтоол
1	Металл материалын ширээсийг эвдэж шалгах сорилт. Хугалах туршилт	MNS ISO 9017:2007	Стандартчилал, Хэмжил зүйн Үндэсний Зөвлөлийн 2007 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 23 дугаар тогтоолын хавсралтын 4 дэх заалт
2	Ширээсийн үл эвдэх сорил. Хайлцуулж ширээсэн холболтын гадна үзлэг сорил	MNS ISO 17637:2005	Стандартчилал, Хэмжил зүйн Үндэсний Зөвлөлийн 2005 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 63 дугаар тогтоолын хавсралтын 4 дэх заалт

